



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1998 оны 5 дугаар
сарын 7-ны одор

Дугаар 53

Улаанбаатар
хот

Эрүүл мэндийн, Эмийн, Ариун цэврийн тухай хуулиудыг баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Эрүүл мэндийн, Эмийн, Ариун цэврийн тухай хуулиудыг баталсантай холбогдуулан дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /Ц.Элбэгдорж/-т даалгасугай:

1/НИЙТ ИРГЭН, ЯЛАНГУЯА ЭРҮҮЛ МЕНДИЙН САЛБАРТ АЖИЛЛАГЧ, СУРАЛЦАГЧДАД ЭРҮҮЛ МЕНДИЙН, ЭМИЙН, АРИУН ЦЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ СУРТАЛЧЛАХ АЖЛЫГ ТУСГАЙЛАН ТӨЛӨВЛӨЖ ЗОХИОН БАЙГУУЛАХ;

2/ЗАСГИЙН ГАЗРААС БАТАЛСАН ХОЛБОГДОХ ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙГ УГ ХУУЛИУДАД НИЙЦҮҮЛЭН МӨРДҮҮЛЭХ;

3/ЭРҮҮЛ МЕНДИЙН, ЭМИЙН, АРИУН ЦЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ДҮРЭМ, ЖУРАМ, НОРМАТИВ, БУСАД БАРИМТ БИЧГИЙГ 1998 ОНЫ 7 ДУГААР САРЫН 1-НИЙ ДОТОР БАГТААН БАТАЛЖ МӨРДҮҮЛЭХ;

4/ЭРҮҮЛ МЕНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТЕХНОЛОГИ, СТАНДАРТ, МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ БОЛОВСРОНГҮЙ БОЛГОЖ, ҮР НӨЛӨӨГ НЬ ДЭЭШЛҮҮЛЭХ;

5/ХҮН АМД НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЕНДИЙН БОЛОН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭН АЖИЛЛАЖ БАЙГАА ЭРҮҮЛ МЕНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫГ ЭНЭ ХУУЛИЙН ДАГУУ УЛСЫН БҮРТГЭЛД БҮРТГҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ АРГА ХЭМЖЭЭГ 1998 ОНЫ Ш УЛИРЛААС ЭХЛЭН 1999 ОНЫ 1 УЛИРАЛД БАГТААН ЗОХИОН БАЙГУУЛАХ;

6/АНАГААХ УХААНЫ БОЛОН СУВИЛАХҮЙН БОЛОВСРОЛ ЭЗЭМШҮҮЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ СУРГУУЛЬ ТӨГСЭЖ, 2 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ЖИЛ АЖИЛЛАСАН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙГ ШАЛГАРУУЛАЛТАД ХАМРУУЛЖ ЭМЧЛЭХ, СУВИЛАХ, ЭМ БАРИХ НАРИЙН МЭРГЭШЛИЙН ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖЛЫГ 1998 ОНЫ Ш УЛИРЛААС ЭХЛЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ БА ТЭДГЭЭРИЙН МЭДЛЭГ, МЭРГЭШЛИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭГ ҮЕ ШАТТАЙГААР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ;

7/АНАГААХ УХААНЫ БОЛОН СУВИЛАХҮЙН БОЛОВСРОЛ ЭЗЭМШҮҮЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ СУРГУУЛЬ ТӨГСӨӨГҮЙ, УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ЧИГЛЭЛЭЭР АЖИЛЛАЖ БАЙГАА

хүмүүсийг шалгаруулалтад оруулж, эмчлэх, сувилах, эм барих үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох ажлыг 1998 оны Ш улирлаас эхлэн зохион байгуулах;

8/Эрүүл мэндийн тухай хуульд хуулиар зохицуулахаар заасан асуудлаар холбогдох хуулийн төслүүдийг боловсруулж, Улсын Их Хурлын 1998 оны намрын чуулганд хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлэх.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороо /Х.Хулан/-нд даалгасугай.

ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ